

БАТЛАВ
ИТХ-ЫН ДАРГА *Ц.Чинбаяр* Ц.ЧИНБАЯР

**НИЙТИЙН СОНСГОЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

Сонсголын зорилго: Орон нутгийн хөгжилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх

Зорилт: Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурал болон Засаг даргын Тамгын газрын төлөөлөл, иргэдэд Нийтийн сонсголын тухай хуулийн мэдээллийг өгөх

“Сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн ажлын хэрэгжилт”-ийн тухай төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулах

Зохион байгуулагч: Бат-Өлзий сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал

Хугацаа, байршил: 2023 оны 11 дугаар сарын 13-ны өдрийн 11 цагт сумын Соёлын төвд

Нийтийн сонсгол зохион байгуулах тухай:

11:00 цагт Нийтийн сонсголын үйл ажиллагааг нээх \сумын ИТХ-ын дарга Д.Цэрэнтогтох\


11:10 Нийтийн сонсголын үйл ажиллагааг дэгийн дагуу зохион байгуулах

11:20 Нийтийн сонсголын үйл ажиллагааг үргэлжлэх

14:00 Нийтийн сонсголын үйл ажиллагааг хааж үг хэлэх

Хүрэх үр дүн: Нийтийн сонсголыг зохион байгуулснаар орон нутагт хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлын талаар иргэдэд үнэн зөв бодит мэдээлэл хүргэнэ.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын алба



Нийтийн сонсголын дэг

Нийтийн сонсголын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан “Сонсголын нийтлэг журам”, Монгол улсын Их хурлын 2017 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Нийтийн сонсгол зохион байгуулах журам”-ын 4-т заасны дагуу энэхүү дэгийг тогтоов.

Энэхүү дэгийг сонсоод оролцогч нийт оролцогчид дагаж мөрдөнө.

- Нийтийн сонсгол хийж байгаа сэдвээр сонсголд дуудагдсан албан тушаалтнаас 15 минутын хугацаанд мэдээлэл өгнө.
- Сонсголд оролцохоор бүртгүүлсэн иргэн, мэргэжлийн холбоо болон төрийн бус байгууллагын төлөөлөл нь сонсголын танхимд ирсэн хугацааны дагуу санал хэлнэ.
- Сонсголд оролцогч 5 минутын хүртэл хугацаанд багтаан үг хэлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүст үг хэлэх хугацааг шаардлагатай хэмжээгээр сунгаж олгоно.
- Асуултыг амаар болон бичгээр сунгаж болно.
- Сонсголын асуудалтай холбогдуулан бичгээр ирсэн санал, хүсэлт, мэдээллийг сонсгол даргалагчаас уншиж танилцуулан тэмдэглэлд тусгуулна.
- Санал, тайлбар дүгнэлттэй холбогдуулан оролцогчоос асуулт асуух хугацаа 4 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байна.
- Асуулт хариулт дууссаны дараа сонсголд оролцогчдоос санал дүгнэлтээ 2 минутаас илүүгүй хугацаанд хэлнэ.
- Сонсголд оролцогч асуулт асуух, үг хэлэхдээ сонсголын сэдвээс өөр сэдвийг хөндсөн тохиолдолд сонсгол даргалагчаас асуулт асуух, үг хэлэхийг хязгаарлаж болно.
- Оролцогчид сонсголын үеэр хуралдаан даргалагч бусад оролцогчоос асуулт асуухгүй.
- Сонсголд оролцогч бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдыг доромжлох, бусдын яриаг таслах, зөвшөөрөлгүйгээр үг хэлэх, хашхирах, шүгэлдэх зэргээр бусдад үгээ чөлөөтэй хэлэхэд саад учруулсан болон сонсгол зохион байгуулагч, сонсгол даргалагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс татгалзвал сонсгол даргалагч дэг баримтлахыг шаардаж, шаардлагыг үл биелүүлбэл ажлын алба оролцогчийг танхимаас гаргаж болно.
- Сонсгол оролцогч нь Нийтийн сонсголын тухай хуулийн 15.2 -т заасны дагуу:
 - Сонсгол хийх журам, дэгийг сахих
 - Сонсгол зохион байгуулагч болон сонсгол даргалагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх
- Сонсголын асуудлаар гаргасан тайлбар, санал, дүгнэлт нь үнэн бодитой байх үүргийг тус тус хүлээнэ.
- Ажиглагч сонсголын үед асуулт асуух, үг хэлэх эрх эдлэхгүй.
- Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн этгээдийг сонсголд оролцуулахыг хориглоно.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны төсвийн зарцуулалт,
гүйцэтгэлийн хяналтын сонгол оролцох ажиглагчдын бүртгэл

2023.11.13

Бат-Өлзий сум

№	Овог нэр	Эрхэлдэг ажил	утас	Гарын үсэг
1	Н.Гэрэлмаа	СОББ багш	99919978	Гэрэлмаа
2	Д. Мунцаа	СОББ багш	94484418	Д. Мунцаа
3	Д. Санжияа сүрэн	байцаагч монтёр	99320885	Санжияа
4	Дамбаагчид	Дамбаагчид	95795439	Дамбаагчид
5	В. Бамбаагчид	БЗД	99777466	Бамбаагчид
6	Х. Нунцаагчид	Хувьцаагчид	99607868	Нунцаагчид
7	М. Нунцаагчид	Б.З.Д	9933789	Нунцаагчид
8	М. Дунцаагчид	на д	99411275	Дунцаагчид
9	М. Чингэлмаа	СОББ-ийн багш	9578101	Чингэлмаа
10	П. Бунцаагчид	ЕБС-ийн багш	99740983	Бунцаагчид
11	Б. Дунцаагчид	Мэргэжлийн багш	95121698	Дунцаагчид
12	Д. Санжияа сүрэн	Хөдөлмөрчид	99792758	Санжияа
13	Д. Дунцаагчид	ЗДТ-ийн мөргөж	98471671	Дунцаагчид
14	В. Ординар	ЗДТ-ийн мөргөж	99125397	Ординар
15	М. Согномолмаа	СОББ-ийн мөргөж. Н.С.	95183322	Согномолмаа
16	А. Чунцаагчид	СОББ-ийн мөргөж. Чингэлмаа	95936892	Чунцаагчид
17	Д. Дунцаагчид	БЗД	94274715	Дунцаагчид
18	Н. Дунцаагчид	Хөдөлмөрчид	99191940	Дунцаагчид
19	М. Гунцаагчид	МЭГ-ийн мөргөж	94984826	Гунцаагчид
20	Ц. Гунцаагчид	МЭГ-ийн мөргөж	94458831	Гунцаагчид
21	М. Дунцаагчид	МЭГ-ийн мөргөж	99662166	Дунцаагчид
22	Д. Дунцаагчид	МЭГ-ийн мөргөж	95634839	Дунцаагчид
23	М. Дунцаагчид	ЕБС багш	99023147	Дунцаагчид
24	Б. Дунцаагчид	ЕБС багш	99017980	Дунцаагчид
25	Тогтоолмаа	МЭГ-ийн мөргөж	807326	86 02 Тогтоолмаа
26	Д. Дунцаагчид	ТТС мөргөж	95118050	Дунцаагчид
27	М. Согномолмаа	МЭГ-ийн мөргөж	88226426	Согномолмаа
28	Д. Мунцаа	Эрчим тээврийн мөргөж	99325565	Мунцаа
29	Д. Дунцаагчид	Санхүүгийн албагчид	99991349	Дунцаагчид
30	Н. Ган-Ординар	ЗДТ-ийн мөргөж	98111976	Ган-Ординар
31	М. Ган-Ординар	МЭГ-ийн мөргөж	85000091	Ган-Ординар
32	Бунцаагчид	Хувьцаагчид	85660363	Бунцаагчид
33	Дунцаагчид	Хувьцаагчид	80424292	Дунцаагчид
34	Дунцаагчид	Хөдөлмөрчид	99442222	Дунцаагчид
35	Т. Нунцаагчид	МЭГ-ийн мөргөж	85831005	Нунцаагчид
36	Дунцаагчид	МЭГ-ийн мөргөж	99919748	Дунцаагчид
37	Дунцаагчид	МЭГ-ийн мөргөж		Дунцаагчид

Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны төсвийн зарцуулалт,
гүйцэтгэлийн хяналтын сонсгол оролцох оролцчдын бүртгэл

2023.11.13

Бат-Өлзий сум

№	Овог нэр /	Эрхэлдэг ажил	утас	Гарын үсэг
1	<i>М. Доржиев</i>	<i>ИТХ-ын талбар</i>	<i>88069973</i>	<i>М. Доржиев</i>
2	<i>М. Сүхбаатум</i>	<i>Гувиараа</i>	<i>99225657</i>	<i>М. Сүхбаатум</i>
3				
4				
5				
6				

ТӨСВИЙН ХЯНАЛТЫН СОНСГОЛ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

2023.11.13

Өвт

2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 11 цаг 30 минутад сумын Соёлын төвд Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны төсвийн зарцуулалт, гүйцэтгэлд хяналт хийх Нийтийн сонсголын үйл ажиллагаа эхлэв.

Төсвийн хяналтын нийтийн сонсголын зохион байгуулагчаар иргэдийн Төлөөлөгчийн Хурлын дарга Ц.Чинбаяр, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, сонсгол даргалагчаар ИТХ-ын төлөөлөгч Г.Пүрэвтогтох, дуудагдаж ирсэн албан тушаалтнаар ЗДТГ-ын дарга Н.Бат-Эрдэнэ, Санхүүгийн албаны дарга О.Отгонтуяа 1-р багийн Засаг Ж.Нямтогтох, 2-р багийн Засаг дарга Д.Бямбасүрэн, "Хутагт уулын өгөөж" мал эмнэлгийн аж ахуйн нэгжийн захирал П.Содномбалжир, эрчим техникч Д.Мөнх нар, оролцогчоор Ж.Хүнийхүн, М.Сумъяацэцэг, шинжээчээр Э.Дашдулам, ажиглагчаар 30 иргэн, албан хаагч оролцлоо. Сонсголын үйл ажиллагааг нээж ИТХ-ын дарга Ц.Чинбаяр үг хэллээ.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Ц.Чинбаяр /ИТХ-ын дарга/: Нийтийн сонсголын гол зорилго нь иргэдийг мэдээллээр хангаж, оролцоог нэмэгдүүлэх, 2017 онд батлагдсан хуулийн хэрэгжилтийг хангахад оршино. 2022 онд Нийтийн сонсголыг зохион байгуулсан. Энэ жил 4 дэх удаагаа зохион байгуулж байна. Сонсгол нь хууль тогтоох, ерөнхий хяналтын, төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулдаг.

Захиргааны хэм хэмжээ тогтоох сонсголыг зохион байгуулж болно. Өнөөдөр 2022 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажилд сонсголыг зохион байгуулж байна.

Г.Пүрэвтогтох\Сонсгол даргалагч\: Сайн байцаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Сумын ИТХ-ын Нийтийн сонсголыг дэгийг уншиж танилцуулав. Дэгийг хавсаргав.

Нийтийн сонсголд хийж байгаа сэдвээр сонсголд дуудагдсан албан Сонсголд оролцогчид үг хэлэхдээ 5 минут, амаар болон бичгээр асуулт асууж болно. Асуулт 4 минут, дараагийн удаа 1 минут, үг хэлэхдээ 3 минут байна.

Ажиглагчид үг хэлж, асуулт асуухгүй. Ингээд үйл ажиллагаандаа орёе. Сумын санхүүгийн албаны дарга О.Отгонтуяа 2022 онд ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын талаар мэдээлэл хийнэ.

О.Отгонтуяа \Дуудагдсан албан тушаалтан, Санхүү албаны дарга\:
ОНХСангийн санхүүжилт 652,764,908 төгрөгийн эх үүсвэрээр дараах ажлууд хийгдсэн. Зөрүүлэг багийн төвд Халуун ус барих 57,574,472 сая, Асгана булгийн эх хаших 15,0 сая, 2-р багийн төвийг тогтой болгох 10/кВ, 100кВА КПТ-ын материал худалан авах 28,611,500 сая, 2-р багийн төвийг тогтой болгох 10/кВ, 100кВА КПТ-ыг холбох ажлын хөлс 17,0 сая, Улаан-Ам, Бүрэгтий, Улиастай багийн үхэр сүргийн 70 хувьд цусан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт хийх 35,200,00

сая, Өвт, Зөрүүлэг, Хүйтэн булаг багийн үхэр сүргийн 70 хувьд цусан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт хийх 19,800,000 сая, Улаан-Ам 1-р багт Өвчний фонд, агуулах барих 53,908,008 сая, Улаан-Ам багийн Улааны булгийн эх хаших 4,0 сая, Бүрэгтий багийн Зүүн сөдтийд худаг гаргах 23,701,565 сая, Улаан-Ам багийн Хөнөгт малын тарилгын хашаа барих 2,0 сая, Бүрэгтий багийн Зүүн, Баруун сөдтийд малын тарилгын хашаа барих 5,0 сая, Их Мойлтод малын тарилгын хашаа барих, Мойлтод булгийн эх хаших 4,0 сая, Зөрүүлэг баг Нарийн, Онгоцотод малын тарилгын хашаа барих 4,0 сая, Улиастай баг Цагаан-Азарга, Шивэртий, Хурц, Улиастайн дэнж, Бөөрөгт мал тарилгын хашаа барих 5,0 сая, Улиастай баг Цагаан-Азаргад Нүдийн булгийн эх хаших 4,300,000 сая, 1-6 дугаар багийн малчин иргэдэд сургалтын зардал 9,0 сая, 2,4-р багт худагнууд засварлах 10,0 сая, Малчин иргэдэд ногоон тэжээл тариалах үр 7,140,000 сая, Гамшгаас хамгаалах зардал 18,600,000 сая, ажлууд гүйцэтгэсэн байдлыг тайлбарлав.

Г.Пүрэвтогтох\Сонсгол даргалагч\: Отгонтуяадаа баярлалаа. Оролцогчид 5 минутад багтааж үг хэлнэ. Мэдээлэлтэй холбоотой асуулт, санал байна уу.

Ж.Хүнийхүн\оролцогч\: Үерийн далан барих ажил 2022 онд хэдэн хэдэн хувийн гүйцэтгэлтэй байсан. 2023 онд хэдэн хувьтай ямар үе шаттай явагдаж байна вэ?

Г.Пүрэвтогтох\Сонсгол даргалагч\: Оролцогч Хүнийхүнийн асуултад ЗДТГ-ын дарга Н.Бат-Эрдэнэ мэдээлэл өгнө үү

Н.Бат-Эрдэнэ \Дуудагдаж ирсэн албан тушаалтан, ЗДТГ-ын дарга\: Нийтийн сонсголд хүрэлцэн ирсэн нийт иргэд та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Рамын дэнжийн үерийн далангийн хувьд 2022 онд ОНХС-ийн хөрөнгөөс 186,0 сая төгрөг төлөвлөгдөж байсан. 2022 онд үерийн далангийн зураг төсөв хийгдээгүй байсан. Зураг төслийн хагас жилд хийлгээд тендер зарласан боловч гүйцэтгэгч компани оролцоогүй үүнээс болж үерийн далан барих ажил хугацааны хувьд хойшилсон. 2022 онд 13.3 хувь нь ОНХС-ийн хөрөнгөөс хийгдэхээр төлөвлөсөн байсан боловч хийгдээгүй шалтгаан нь нийт 3,5-р багт 5 трансийн зураг төсвөөр үерийн далан барихад нийт тэрбум 200 сая төгрөгийн төсөвт өртөг шаардалагатай тухайн жилд 186.0 сая төгрөг төлөвлөн гэдэг үерийн далангийн ажлын 13.3 хувийн төсөвт өртөг энэ дээр тендер зарлаад зураг төсвийн 1,2-р трансс буюу Наймаа булангийн 170м, 2-р хорооллын ар, 3-р хорооллын хэсгийн 196м газарт үерийн далан хийлгэхээр тендер зарласан компани оролцоогүй. Үерийн далангийн 1,2-р трансс зураг төслийн дагуу 100% гүйцэтгэсэн.

Г.Пүрэвтогтох\Сонсгол даргалагч\: За баярлалаа. Дараагийн оролцогч Сумъяацэцэгийг урьж байна.

М.Сумъяацэцэг\оролцогч\: Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын төсөв хүртээмж хэр байсан, бүх малчин өрхийн малд хүрч ажиллаж байна уу?

Г.Пүрэвтогтох\сонсгол даргалагч\: Сумъяацэцэгийн асуултад Содномбалжир хариулна уу.

П.Содномбалжир \Дуудагдаж ирсэн албан тушаалтан\: Малын тоо толгойн албан татвараас 3,4,5-р багт 19,800,000 сая төгрөг төсөвлөсөн байсан энэхүү төсвөөр 100% үхэр сүрэгт цусан халдварт өвчний дархлаажуулалт хийгдсэн байгаа. 2023 онд цусан халдварт өвчнөөр үхсэн мал байхгүй тийм учраас энэ ажил их үр дүнтэй болсон гэж үзэж байна. Санхүүгээ 1500 төгрөгөөр бодож малын тоогоо

үржүүлсэн байсан энэ нь цаанаасаа бид нар мал эмнэлгийн хүрээлэнтэй гэрээ хийгээд мал эмнэлгийн шинээр гаргасан нэг удаагийн тунтай вакцин хийсэн. Энэ нь үр дүн өндөртэй байсан аль болох бүх малчин өрхөд хүрч ажилласан. Санхүүжилтийн хувьд хүрсэн.

Г.Пүрэвтогтох\сонсгол даргалагч\: Оролцогч Хүнийхүнийг урьж байна.

Ж.Хүнийхүн\оролцогч\: 6 багт сургалт, сурталчилгаа явуулахад нийт хэдэн хүн хамрагдсан, зорилтот бүлгийн малчид бүрэн хамрагдсан уу?

Н.Бат-Эрдэнэ\Дуудагдаж ирсэн албан тушаалтан, ЗДТГ-ын дарга\: Малын тоо толгойн албан татвараас 2022 онд сургалт, сурталчилгаа дээр 1 багт 1,5 сая төгрөг төсөвлөсөн 6 баг дээр сүү цагаан идээ бэлтгэх сургалтыг хэсэгчлэн зохион байгуулсан. 6-р баг дээр 5 хэсэгт 80 малчин өрх хамрагдсан, 1-р багт сүү цагаан идээ бэлтгэх сургалтыг 4 хэсэгт зохион байгуулж 135 иргэн хамрагдсан. 2-р баг дээр монгол гутлын сургалтыг 17 иргэнд 10 хонгийн хугацаатай зохион байгуулсан, 4-р баг хууль эрх зүйн сургалт өгсөн.

Г.Пүрэвтогтох\Сонсгол даргалагч\: за баярлалаа. Оролцогч Сумъяацэцэгийг урьж байна.

М.Сумъяацэцэг\Оролцогч\: Бүрэгтий багийн төв тогтой болгох ажил дээр хийгдсэн ажил юу байна үр дүн, явц хэр байгаа?

Г.Пүрэвтогтох\сонсгол даргалагч\: Д.Мөнх асуултад хариулна уу.

Д.Мөнх\Дуудагдаж ирсэн албан тушаалтан\: Бүрэгтий багийг тогтой болгох материал худална авах ажлыг хийж гүйцэтгэсэн. 2022 оны 11 сард хийж гүйцэтгэх ёстой байсан одоогоор 80%-тай явж байна одоо 4,5км цахилгаан агаарын шугам татаж гүйцэтгэсний дараа үлдсэн 20%-ийг хийж гүйцэтгэх төлөвлөгөөтэй байна.

Г.Бямбагарав\сонсгол даргалагч\: За баярлалаа. Оролцогч Хүнийхүнийг урьж байна.

Ж.Хүнийхүн\Оролцогч\: Улаан-Ам багийн төвд өвсний фондын агуулах барьсан малчид нь ашиглаж байгаа юу ямар зориулалтаар ашиглаад байна вэ?

Г.Пүрэвтогтох\сонсгол даргалагч\: ЗДТГ Бат-Эрдэнэ асуултад хариулна уу.

Н.Бат-Эрдэнэ\дуудагдсан албан тушаалтан\: Улаан-Ам багт 2022 онд Малын тоо толгойн албан татвараас 55,0 сая төгрөгөөр өвсний фонд барихад төсөвлөж тендер зарлан “Үлэмж үнэлгээ” ХХК шалгарч хийж гүйцэтгэсэн. Одоогийн байдлаар тухайн өвсний фондод Улаан-Ам, Улиастай багийн малчид өөрсдийн хувийн хадлан тэжээлээ нөөцөлж хийсэн байгаа сумын аюулгүйн нөөцийн өвснөөс нөөцөлж хийсэн юм байхгүй байна.

Г.Пүрэвтогтох\сонсгол даргалагч\: Оролцогч М.Сумъяацэцэгийн урьж байна.

М.Сумъяацэцэг\Оролцогч\: Бүрэгтий багт худаг гаргах асуудал бас худаг засварын ажлыг ямар компани хийж гүйцэтгэсэн одоо бүрэн ашиглаж байгаа юу?

Г.Пүрэвтогтох\сонсгол даргалагч\: Оролцогч умъяацэцэгийн асуултад ЗДТГ-ын дарга хариулна уу.

Н.Бат-Эрдэнэ\ЗДТГ-ын дарга\: 2,4-р багууд дээр тус тус 2 худгийн мотор, нацосс, шоланк солих, цонх хаалга солих засварын ажлыг “Уран шунхлай” ХХК хийж гүйцэтгэсэн. Одоо 100% ашиглагдаад явж байна.

Г.Пүрэвтогтох\сонсгол даргалагч\: Оролцогч М.Сумъяацэцэгийн урьж байна.

М.Сумъяацэцэг\Оролцогч\: Зөрүүлэг багийн төвд баригдсан Халуун ус одоо ашиглалтад орсон байгаа юу?

Г.Пүрэвтогтох\сонсгол даргалагч\: Оролцогч Сумъяацэцэгийн асуултад ЗДТГ-ын дарга хариулна уу.

Н.Бат-Эрдэнэ\ЗДТГ-ын дарга\: Зөрүүлэг багийн төвд баригдсан халуун ус одоо ашиглалтад орсон үсчин дотор нь ажиллаж байгаа ойр орчмын иргэд болон зам ангийн ажилчид үйлчлүүлж байна.

Г.Пүрэвтогтох\сонсгол даргалагч\: Оролцогч Ж.Хүнийхүнийг урьж байна.

Ж.Хүнийхүн\Оролцогч\: Малын тоо толгойн албан татварын 2022 оны орлого бүрдүүлэлт таслагдсантай холбоотой төлөвлөсөн ажлуудаас хийгдээгүй хэдэн ажил үлдсэн бэ?

Г.Пүрэвтогтох\сонсгол даргалагч\: Оролцогч Хүнийхүний асуултад ЗДТГ-ын дарга хариулна уу.

Н.Бат-Эрдэнэ\ЗДТГ-ын дарга\: Малын тоо толгойн албан татвараас 2022 онд нийт 27 ажил хийнэ гэж төлөвлөсөн үүнээс 23 ажил хийгдэж 4 ажил орлогоос шалтгаалаад хийгдээгүй үлдсэн байна. хийгдээгүй ажлууд Хүйтэн булагийн Мухар хустын булгийн эх хаших, сумын төвд мал тарилгын хашаа барих, Урд Агуйт, Цагаан гол, Намгийн голын эх хаших, Их булагт мал тарилгын хашаа барих гэх ажлууд үлдсэн байна.

Г.Пүрэвтогтох\сонсгол даргалагч\: За баярлалаа. Оролцогч Сумъяацэцэгийг саналаа хэлнэ үү гэж урьж байна.

Санал дүгнэлт:

М.Сумъяацэцэг\Оролцогч\: Булгийн эх хаших, Худаг барих ажлуудыг цаашид хийгээд байх ажлууд биш болцон хангалтай хийгдсэн байна гэж үзэж байна. Төсөвт өртгөө өндөрсгөж заавал багууд дээр гээд байхгүй сумын хэмжээндээ иргэдэд хэрэгтэй юу байна тийшээ чиглэсэн ажлууд хиймээр санагдаж байна.

Г.Пүрэвтогтох\сонсгол даргалагч\: За баярлалаа. Оролцогч Хүнийхүнийг урьж байна.

Ж.Хүнийхүн\Оролцогч\: ОНХСангийн хөрөнгөөр хийгдэж байгаа ерөнхийдөө сайн хийгдсэн. ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын зарим асуултад миний хувьд бүрэн гүйцэт хариулт авч чадсангүй гэж үзэж байна. Мал тарилгын хашаа, булгийн эх хаших ажлууд 6 багийн хувьд хангалттай хийгдсэн ажил гэж үзэж байна. Улаан-Ам багт баригдсан өвсний фонтын үйл ажиллагааг нь жигдрүүлээд явмаар байна.

Г.Пүрэвтогтох\сонсгол даргалагч\: Санал хариулт авч дууслаа. Өнөөдрийн нийтийн сонсголд оролцсон нийт оролцогчдодоо баярлалаа. Ц.Чинбаяр\зохион байгуулагч\: Сонсгол энэ хүрээнд өндөрлөж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны төсвөөр хийж хэрэгжүүлсэн ажлын талаар тодорхой хэмжээний чиглэл, ойлголттой боллоо.

Сонсголд Зарим нэг оролцогч асуултад бүрэн дүүрэн хариулт авч чадаагүй нь Засаг дарга, ЗДТГ, Санхүү алба нь нийтийн сонсголын бэлтгэл бүрэн хангадаагүйг анхаарах хэрэгтэй.

Өнөөдрийн нийтийн сонсголд оролцсон албан тушаалтан, аж ахуйн нэгж, иргэд та бүхэндээ баярлалаа. Ажлын амжилт хүсье.

Нийтийн сонгогч 13:35 цагт өндөрлөв.

ТАНИЛЦСАН:

ИТХ-ЫН ДАРГА *Ц.Чинбаяр* Ц.ЧИНБАЯР

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ОЛОН НИЙТТЭЙ
ХАРИЛЦАХ МЭРГЭЖИЛТЭН *Г.Сугар* Г.СУГАР